



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/47

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хоёрдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Батбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар /О.Энхболд/-т даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

141250279

Эрүүл мэндийн сайдын 2025 оны  
дугаар сарын 12-ны өдрийн  
дугаар тушаалын хавсралт



**МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	Сонгинохайрхан дүүрэг, Буянт манал өрхийн эрүүл мэндийн төв	14/2025	1 жил	2025.02.05	2026.02.05
2.	Улаанбаатар хот, Нууц увидас ХХК-ийн эмнэлэг	15/2025	1 жил	2025.02.05	2026.02.05
3.	Баян-Өлгий аймаг, Дэлүүн сумын эрүүл мэндийн төв	16/2025	2 жил	2025.02.05	2027.02.05
4.	Дорнод аймаг, Цагаан-Овоо сумын эрүүл мэндийн төв	17/2025	2 жил	2025.02.11	2027.02.11
5.	Дорнод аймаг, Чулуунхороот сумын эрүүл мэндийн төв	18/2025	2 жил	2025.03.12	2027.03.12
6.	Сэлэнгэ аймаг, Зүүнбүрэн сумын эрүүл мэндийн төв	19/2025	2 жил	2025.02.14	2027.02.14
7.	Увс аймаг, Сагил сумын эрүүл мэндийн төв	20/2025	1 жил	2025.02.05	2026.02.05
8.	Увс аймаг, Тариалан сумын эрүүл мэндийн төв	21/2025	1 жил	2025.02.05	2026.02.05
9.	Увс аймаг, Увс-Мөнхтэнгэр ХХК-ны Жаргалан эмнэлэг	22/2025	1 жил	2025.02.05	2026.02.05